



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/62Н

Булган сум

Эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, Сангийн сайдын “Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай” 2011 оны 188 дугаар тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оросын Холбооны Улсын Буриад Улсын Хөдөө аж ахуйн академитай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Буриад Улсад малын эмчээр оюутан суралцуулах гэрээ байгуулах, суралцах оюутнуудыг Хөдөө аж ахуйн академид хүргэж өгөх зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Хангал сумын Засаг дарга Сэвжидийн Ичинхорлоог томилолтоор ажиллуулсугай.

2.Томилолтоор ажиллахад шаардагдах зардлыг Хангал сумын Засаг даргын тамгын газрын төсвөөс гаргахыг Хангал сумын Засаг даргын тамгын газрын Нягтлан бодогч (Б.Хүрэлсүвд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010878